



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/137

Булган сум

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсэг, Засгийн газрын 2025 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган суманд эзэмшиж буй газраа бусдад шилжүүлэх хүсэлт гаргасан 6 (зургаа) иргэн, 2 (хоёр) хуулийн этгээдийн газар эзэмших эрхийг энэхүү захирамжийн хавсралтад дурдсан 7 (долоо) иргэн, 1 (нэг) хуулийн этгээдэд шилжүүлсүгэй.

2.Газар эзэмших эрх шилжүүлэн авсан иргэн, хуулийн этгээдтэй газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, эрхийн гэрчилгээг баталгаажуулан, газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан хавсралтад заасан аймгийн Засаг даргын захирамжуудын холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Д.ЛҮРЭВ-ОЧИР



6326010177